



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/63

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Мөнх хөхий ХХК-ний "Мөнх хөхий" дэн буудлын 13/278, Багануур сувилал ХХК-ний "Уурхайчин" зочид буудлын 13/134, Металл сервис ХХК-ний "Их наяд" зочид буудлын 16/042, Пума Империал ХХК-ний "Пума империал" зочид буудлын 16/047, Бөхбат ХХК-ний "Маргад" зочид буудлын 15/035, Би ди Би Си ХХК-ний "Ану Марал" зочид буудлын 14/40, Атар шим ХХК-ний "Тэргэл-1" зочид буудлын 15/062, Атар шим ХХК-ний "Тэргэл-2" зочид буудлын 15/059, Атар шим ХХК-ний "Тэргэл-3" зочид буудлын 15/060 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд

төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-т даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огтонсууд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 08 сарын 09 өдрийн үзүүлэгтэй Уугаартушаалын нэгдүгээр хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2017.08.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Би Ди Би Си ХХК	5381738	Ану Марал	БГД-ийн 9-р хороо Хасбаатарын гудамж-22
2	Бөхбат ХХК	2565935	Маргад	ЧД-ийн 5-р хороо Их тойруу
3	Пума Империал ХХК	2720035	Пума Империал	СБД-ийн 8-р хороо Их сургуулийн гудамж-2
4	Металл сервис ХХК	2560763	Их наяд	БЗД-ийн 7-р хороо 36а
5	Багануур сувилал ХХК	2009439	Уурхайчин	БНД-ийн 3-р хороо Нацагдоржийн гудамж
6	Атар шим ХХК	2595435	Тэргэл-1	БЗД-ийн 7-р хороо Б.Доржийн гудамж-11
7	Атар шим ХХК	2595435	Тэргэл-2	БГД-ийн 7-р хороо Баруун ард аюушийн 65-5
8	Атар шим ХХК	2595435	Тэргэл-3	БГД-ийн 9-р хороо Хасбаатарын 25-2
9	Ханду ХХК	6188575	Ханду	БГД-ийн 6-р хороо 3-р хороолол Чингунжав-8

--ооОоо--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 08 сарын 03
өдрийн 1003 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.08.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх хөхий ХХК	2833158	Мөнх хөхий	БЗД-ийн 16-р хороо Да хүрээ-57

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 08 сарын 03-
өдрийн 11:53 дугаар тушаалын
туравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.08.02

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мянган лант Холдинг ХХК	2542862	Тэрэлж маунтайн лодж	НД-ийн 6-р хороо Горхи Тэрэлж Залаатын ам

--ооОоо--